

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРААС
2016 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2016.06.06

/Хяналтанд авсан заалтаар/

Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Хувь
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, аймгийн онцгой байдлын газартай хамтарч ажиллах.	Хууль зүйн сайдын 2013 оны 1/1210 тоот албан даалгаврын дагуу орон нутаг дахь хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах хүрээнд 14 хоног тутамд тэдгээр байгууллагуудын удирдлага, албан хаагчдын уулзалтыг байгууллагууд ээлжлэн зохион байгуулж, уг уулзалтаар өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлахын хамт орон нутагт хууль хяналтын чиглэлээр тулгамдаж байгаа асуудлууд, шийдвэрлэх арга замуудыг хэлэлцэн, нэгдсэн ойлголтод хүрч, тохиролцсон асуудлаа хамтран шийдвэрлэж байна. Манай байгууллага 3-р сарын 11-ний өдөр болсон уулзалтыг хариуцан зохион байгуулсан.	100
2	Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын хувьд эрхэлж байгаа ажил үүргийн онцлогтой холбогдон өртөж болзошгүй гэмт хэрэг, зөрчил, түүний үр дагаврын тапаар мэдээлэл, сэрэмжлүүлэг өгөх, уулзалт зохион байгуулах	Албан хаагчдад мэдээлэл, сэрэмжлүүлэг, зааварчилгааг тогтмол өгч, авлига болон бусад зөрчлөөс ангид байх баталгаа гаргуулах, сургалт, ярилцлага зохиох зэргээр ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар гарсан зөрчил байхгүй байна. Статистикийн хэлтсийн судлаачийн хувьд аливаа гэмт халдлагад өртөхгүй байх, болгоомжтой, хянуур ажиллах талаар судалгаанд явах бүрт нь заавар, зөвлөмж, анхааруулга өгч байна. Мөн хамт явах хөтөч, жолоочид аюулгүй байдлыг хангах талаар заавар, зөвлөгөө өгч ажилладаг.	100
3	Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлын талаар албан хаагчдын дунд тодорхой мэдлэг, ойлголт олгох зорилгоор мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлан түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	Мэдээлэл технологийн ажилтан аюулгүй байдлыг хангахад анхаарч, тогтмол зөвлөмж, заавар өгч, кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сэрэмжлүүлэг, зааварчилгааг тогтмолжуулсан. Мэдээллийн сүлжээнд нэвтрэх эрх бүхий албан хаагчид болон сонгуульд ажиллах иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудаас нууцын баталгаа гаргуулсан.	100
4	Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд харьцаж, ажиллаж байгаа албан хаагчдад мэдээллийн сангийн аюулгүй байдлын талаар зааварчилгаа өгөх, үйл	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудлаар 3-р сард албан хаагчдын дунд сургалт зохион байгууллаа. Мөн сүлжээнд нэвтрэх нууц үгийг бүх албан хаагчид улирал тутам шинэчилдэг журмыг мөрдөж хэвшүүлээд байна.	100

	ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах	Улсын бүртгэлийн нэгдсэн сантай харьцаж байгаа албан хаагчдын үйл ажиллагаанд улсын ахлах бүртгэгч болон бүртгэлийн хэлтсийн дарга хяналт тавин ажиллаж байна.	
5	Улсын бүртгэлийн архив болон улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн аюулгүй байдлыг хангах орчин нөхцлийг бүрдүүлэх.	Бүртгэлийн архивын өрөө тасалгааны аюулгүй байдлыг холбогдох журмын хүрээнд сайтар ханган, аюулгүй байдлын дохиолол, утаа мэдрэгч, камер зэргийг суурилуулан, бүх цонхонд хамгаалалтын тор хийсэн. Мөн хаалга үүдийг нь ажлын цаг дуусмагц лацдан, лацны бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн.	100
6	УБСЕГ-ын болон үйлчилгээний байр, газар, хэлтсийн байрны аюулгүй байдлыг хангах, камер дохиоллын системийн хэвийн ажиллагааг хангах.	Улсын бүртгэгч нар "Иргэдэд үйлчлэх төв"-д байрладаг бөгөөд энэ өрөөнд хяналтын камер суурилуулан, байнга хяналт тавин ажиллаж байна. Мөн Улсын бүртгэлийн хэлтсийн архивын өрөө орох коридор хэсэг аймгийн ЗДТГ-ын хяналтын системд холбогдсон. Статистикийн хэлтэст хариуцлагатай жижүүрийн дэвтэр нээж, яаралтай дуудлагын утсыг байршуулсан. Нийтээр тэмдэглэх болон баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг бүх өрөөнд хуваарийн дагуу ажиллуулж байна.	100
7	Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр шинээр томилогдсон болон сэлгэн ажиллаж байгаа албан хаагчдад бүртгэлийн материалын бүрдлыг нягтлах, бүртгэх талаарх сургалтыг тухай бүр зохион байгуулах .	Улсын бүртгэлийн болон статистикийн байгууллагууд нэгдсэнтэй холбогдуулан бүртгэлийн болон статистикийн үйл ажиллагааны талаар бүх албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2 удаа зохион байгуулсан. УБСЕГ-ын хэмжээнд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан цомхотголд орсон хуулийн этгээдийн бүртгэгчийн ажлыг улсын ахлах бүртгэгч Э.Ууганбатад хариуцуулж, түүнийг Улаанбаатар хотод 2 хоног томилон ажиллуулж, хуулийн этгээдийн бүртгэлийн талаар сургалт, дадлага хийлгэсэн.	100
8	Байгууллагын болон албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэн, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй санал гомдол, мэдээллийг хүлээн авч шуурхай шийдвэрлэж ажиллах.	"Иргэдэд үйлчлэх төв" дэх бүртгэлийн үйлчилгээний цонхны дэргэд санал хүсэлтийн хайрцаг байрлуулах, зөвлөх утас /70543306/ ажиллуулах, үйлчлүүлсэн иргэдээс санал асуулгын хуудсаар судалгаа авах, байгууллагын цахим хуудсанд санал, хүсэлтийн булан ажиллуулах зэргээр иргэдийн санал, гомдол, мэдээллийг аль болох өргөн шугамаар авах зохион байгуулалт хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэн, иргэдэд хариу мэдээлэн ажиллаж байна.	80
9	Үйлчилгээний байруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, санамж материалыг байршуулах, тараах, байгууллагын вэб хуудсанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл байршуулах	Хэлтсийн өрөө тасалгаануудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, анхааруулга, санамжуудыг байрлуулсан. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	100

10	Шинээр батлагдсан хууль, тогтоомж, эрх зүйн актын талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэх	Шинээр батлагдсан хууль, тогтоомжуудыг судлах талаар албан хаагчдыг үүрэгжүүлэн ажиллахын зэрэгцээ УБСЕГ-ын даргын тушаалаар шинээр батлагдсан журмуудыг бүх албан хаагчдад тусгай танилцах хуудсаар танилцуулж, гарын үсэг зуруулсан.	100
11	"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль" болон "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр"-үүдийн талаар нийт албан хаагчдад сургалт зохион байгуулах	Хугацаа болоогүй	
12	"Гэр бүлийн хүчирхийлэл ба гэмт хэрэг" сэдэвт эрх зүйн сургалт зохион байгуулж, албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх	Хугацаа болоогүй	
13	"Хуурамч баримт бичиг, түүнийг таних заавар", "Тамга тэмдэг ашиглах, хуурамчаар баримт бичиг үйлдэхээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалтанд улсын бүртгэгчдийг хамруулах, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран холбогдож болзошгүй гэмт хэрэг, зөрчлийн хууль зүйн үр дагаврын талаар мэдээлэл өгөх, сэрэмжлүүлэх сургалт зохион байгуулах.	Хугацаа болоогүй	
14	"Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх нь" сэдэвт эрх зүйн сургалт зохион байгуулж, албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх	Хугацаа болоогүй	
15	Байгууллагын хэмжээнд эрсдэлийг үнэлэх, бүүрүүлэх чиглэлээр хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Хугацаа болоогүй	
16	Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, шалгалт хийх, хяналт шалгалтаар тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргаж, түүний мөрөөр арга хэмжээ авсан байх	Дотоод хяналтыг сайжруулж, сар бүр байгууллагын аль нэг үйл ажиллагаанд тогтмол хяналт, шалгалт хийж, илэрсэн алдаа, дутагдлыг арилгах ажлыг тухай бүр зохион байгуулж ирсэн.	80

17	Албан хаагчдад олгосон торгууль, шийтгэврийн хүүдас, үнэт цаасны хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд шалгалт хийх	Албан хаагчдын ашиглаж байгаа үнэт цаас, торгуулийн хуудасны тооцоог сар бүр гаргуулан авч, нягтлан бодох бүртгэл хөтөлж, түүний зарцуулалтын байдлыг баримттай нь тулган шалгах ажилд улсын ахлах бүртгэгч болон хэлтсийн дарга давхар хяналт тавьж, хүчингүй болгосон үнэт цаасыг хариуцсан ажилтнаар төлүүлэх арга хэмжээг тогтмол авч байна.	100
18	Албан хаагчдын албан болон хувийн хэргийн нүүцлал, хадгалалт, хамгаалалт хангагдсан байдалд хяналт тавьж ажиллах	Албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт болон баяжилтын асуудлыг бичиг хэргийн ажилтанд хариуцуулж, тусгай сейфэнд хадгалж байгаа бөгөөд үүнд газрын дарга хяналт тавин ажиллаж байна.	100
19	Албан хаагчдын "Улсын бүртгэлийн үйлчилгээний стандарт"-ын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах, стандартыг мөрдүүлж ажиллах.	Албан хаагчдын дунд үйлчилгээний стандартыг хэвшүүлэн мөрдүүлэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор газрын дэргэдэх ёс зүйн хорооны гишүүдээр тогтмол хяналт тавиулж, үр дүнг албан хаагчдад танилцуулж, зөрчил, дутагдал гаргасан албан хаагчдад зөвлөгөө, үүрэг даалгавар өгч, үр дүнгийн гэрээг дүгнэхэд харгалзаж үзэхээр ажиллаж байгаагийн үр дүнд үйлчилгээний стандарт бүрэн хэрэгжиж байна.	100
20	Албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг хэрхэн баримталж байгаа болон ажлын байрны дэг журмыг хангаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах, шаардлагатай арга хэмжээг авах	Бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдад тогтмол хяналт тавьж ажилласан. Албан хаагчдын харилцаа болон ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэдээс ямар нэгэн гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100
21	Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн албан хаагчид холбогдох хууль, дотоод журамд заасан хариуцлага тооцох.	Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомжоор уг асуудлыг журамлан зохицуулж байгаа. Ажлын байр дээр согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн албан хаагч одоогоор байхгүй, энэ төрлийн зөрчил дутагдал гараагүй байна.	100
22	Хөдөлмөрийн дотоод журам болон бүртгэл, статистикийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан дүрэм, журмын биелэлтийг хангуулан ажиллах.	УБСЕГ-ын даргын 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/497 тоот тушаалаар батлагдсан "УБСЕГ-ын хөдөлмөрийн дотоод журам"-ыг нийт албан хаагчдад танилцуулж, уг журмын дагуу хөдөлмөрийн харилцааг зохицуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

Ерөнхий хувь – 98,0 хувь

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

Л.НАСАНЖАРГАЛ

Л.ЦЭЛМЭГ



Handwritten signatures of the State Auditor General and the Branch Director.